



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/80

Мандалговь

Г Гэрээ байгуулах тухай Г

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Орон нутгийн хөрөнгөөр санхүүжигдэх “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” хөтөлбөрийн хүрээнд “Бэлэн бус торгуулийн тоног төхөөрөмж” нийлүүлэх ажил “ДУОНӨГ/2017/00021/05”-ын гүйцэтгэгчээр “Ай Си Ай Систем монголиа ХХК”-ийг сонгон 9,988,000 /есөн сая есөн зуун наян найман мянга/ төгрөгөөр шууд гэрээ байгуулсугай.

Хоёр. Тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж, хүлээлгэн өгөхийг “Ай Си Ай Систем Монголиа” ХХК –ний захирал /С.Амар-Өлзийт/-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, тоног төхөөрөмж нийлүүлэх ажилд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Замын цагдаагийн тасаг /Цэндцэсэм/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0200283